



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/374

Мяндалговь

Дундговь түншлэл-2018" үзэсгэлэн,
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.3, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.2.7, Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг Хүн амын хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр хангах өргөн боломжийг бүрдүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлж стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлийн боловсруулах түвшинг ахиулах, харилцан туршлага солилцох түншлэл тогтоох, үйлдвэрлэл үйлчилгээг сурталчлах зорилгоор "Дундговь түншлэл-2018" үзэсгэлэн худалдааг 2018 оны 9 дүгээр сарын 28,29-ний өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулсугай.

Хоёр. "Дундговь түншлэл-2018" үзэсгэлэн худалдаанд оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шалгаруулах номинац, шалгуур үзүүлэлтийг гаргаж, нийт сумд, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

Гурав. "Дундговь түншлэл-2018" арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Дөрөв. Уг арга хэмжээнд шаардлагатай 1.950.000 (Нэг сая есөн зуун тавин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010278

Аймгийн Засаг даргын 2018 оны 09
дүгээр сарын 05-ны өдрийн 1374 тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт



"Дундговь түншлэл-2018" үзэсгэлэн худалдааг
зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга: Н.Эрдэнэ-Очир - ХОХБТХ-ийн дарга

Нарийн бичгийн дарга: Д.Энхтуяа - ХОХБТХ-ийн мэргэжилтэн

Гишүүд: О.Мөнхзул - ХОХБТХ-ийн мэргэжилтэн

П.Очирбат - ХОХБТХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхжаргал - ХХААГ-ын дарга

Г.Хишигдаваа – ХХҮГ-ын дарга

А.Пүрэвсүрэн – СХЗХ-ийн дарга

Б.Цэрэнханд - ХХААГ-ын мэргэжилтэн

Ж.Мөнхбаяр - ХХААГ-ын мэргэжилтэн

Э.Эрдэнэтунгалаг - ХХААГазрын агрономич

Д.Дэнсмаа – СХЗХ-ийн мэргэжилтэн


Д.Отгонтөгс - Хүнсчдийн холбооны салбарын тэргүүн

Ш.Оюун – МТнХолбооны Дундговь аймаг дахь салбарын тэргүүн

О.Пунсанцогвоо - МХАҮТанхимын салбарын менежер

Ж.Зоригтбаатар - Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

Аймгийн Засаг даргын 2018 оны 09
дүгээр сарын 05-ны өдрийн А/ЗДТ
захирамжийн хоёрдугаар хавсралт



"Дундговь түншлэл-2018" үзэсгэлэн худалдааны
шагналын зардлын жөгсаалт

№	Зардлын нэр	Х/нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Зардал хариуцах байгууллага
Засаг даргын нөөц сангаас шагнагдах шагналууд						
1	Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
2	Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц сан
3	Шилдэг Хүнсний бусад нэрийн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
4	Шилдэг Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
5	Шилдэг гар урлалын болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүн	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц сан
6	Шинэ бүтээгдэхүүн, шинийг эрэлхийлэгч аж ахуйн нэгж, иргэн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
7	Нийтийн хоолны салбарын шилдэг үйлдвэрлэгч байгууллага	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
8	Аймгийн брэнд бүтээгдэхүүн	Ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц сан
	ДҮН				1,950,000	